



# Thomas Jefferson Middle School

## IBMYP 12-р сарын сонин



### Энэ сарын шилдэг сурагч: МЭДЛЭГТЭЙ

Бид бүх сурагчдаа **мэдлэгтэй** байгаасай гэж хүсдэг. ОУБ-ын хөтөлбөрийн ихэнх хичээл мэдлэг ойлголт өгөх зорилготой байдаг. Анги бүрд сурагчид шинэ ухагдахууныг ойлгохыг хичээдэг.



Тухайн орон нутгийн асуудлаас эхлэн олон улсын асуудлыг судалдаг. Сурагчид мөн эзэмшсэн шинэ мэдлэгээ янз бүрийн нөхцөлд ашиглахад мөн суралцдаг.

Манай сурагчдын шалгаруулсан шилдэг сурагчид бол: **Далайн гахай - Annie Madden, Луу - Nour Ben Hammouda, Бүргэд - Luke Endo, Матар - Sassan Fiske, Эзэн хаан - Diana Rojas, Шар шувуу - Paige Haydasz, Оцон шувуу - Ava Fischer, Галт шувуу- Juan Sierra, Сувдан загас - Matthew Abramson.** Эх сурвалж: [JeffersonIBMYP](http://JeffersonIBMYP)

### Бичгээр гаргасан сургалтын хөтөлбөр

1 дэх жилийн математикаас 6-р ангийн Алгебрын үндэс, 2 дахь жилийн математикаас 7-р анги хүртэл тооны хичээлийг бодит ертөнц уруу авчирч байна. Алгебрын үндэс хичээлийн сурагчид томоохон зүйл худалдан авахын тулд төсөв гаргах болсон. Зун ямар нэг ажил хийх даалгавар авсан сурагчид худалдан авахыг хүсэж буй хэрэглээний бүтээгдэхүүний өртгийн дүн шинжилгээ хийж, худалдан авах төлөвлөгөө гаргав. 7 дахь жилд математикийн хичээлээр сурагчид Олон улсын хоол хүнсний тухай бүлэг үзсэн. Сурагчид 4-5 хүний порц бүхий гэрийн хоолны жорыг 20-25 сурагчтай бүхэл бүтэн ангийг хооллох жор болгон хувиргахын тулд харьцааны тухай ойлголтоо ашиглав. 12-р сарын 12-нд сурагчид Этиопийн инжерагаас эхлээд Эл Сальвадорын пупуса гээд янз бүргийн орны хоол математикийн хичээл дээр авчирсан юм.



### Бүх нийтийг хамрах журмаа эргэн харахуй



Бүх хүмүүст боловсролыг хүртээмжтэй болгохын тулд манай Бүх нийтийг хамрах журмыг эргэн харах цаг болжээ. ОУБ-ын хөтөлбөрийн *Сургалтын олон янз байдал, хамрагдалтын дагуу* ОУБ хөтөлбөр бүх нийтийн боловсролын талаар хэд хэдэн үндсэн зарчимтай байдаг. Эдгээрийн дотроос

бүх нийтийн боловсрол бол хүний эрх юм. Хоёрдугаарт, багш бүр бүх сурагчдын багш юм. Гуравдугаарт, бүх суралцагч чанартай сургалтад оролцож, боловсрол эзэмших эрх тэгш боломжтой байна. Мөн ОУБ хөтөлбөрийн хүрээнд хувь хүний хэн болохыг ойлгуулж, өөрийгөө хүндэтгэх ёсыг төлөвшүүлж, урьд нь олж авсан мэдлэгийг үнэлж, сурах үйл явцыг бэхжүүлэн өргөжүүлэх зарчмыг баримтлан сургалтын олон янз байдлыг дэмжиж заахад итгэдэг. Ирэх 5 долоо хоногт бид эдгээр зарчмыг тусгахын тулд бүх нийтийг хамрах журмаа эргэн харж шинэчилнэ. Манай [журмыг эндээс үншиж](http://журмыг эндээс үншиж), санал хүсэлт өгнө үү. Эх сурвалж: [pixbay.com](http://pixbay.com)

### ДБХ-ийн анги ба бодит үнэлгээ

Хувь хүмүүс ба нийгэм - Дэлхийн газарзүйн хичээлээр лавлан сонирхох, дараах эргэлзээтэй асуулыг гүн гүнзгий судалж байна: Баруун Африкийн Зааны ясан эрэг улсад үйлдвэрлэсэн шоколад сайн зүйл мөн үү? Тус сэдвээр сурагчид Баримт бичигт суурилсан асуулт (ББСА) бүхий зохион бичлэг бичиж байна. Тус даалгаврыг гүйцэтгэхээр сурагчдыг янз бүрийн бүлгийн түвшинд хуваана. Гурван ангиллаар үндэслэл гаргахын тулд мэдээллээ эмхлэн цэгцлэхийг сурагчдаас шаарддаг онлайн хэрэгслийг тэд ашиглаж байгаа. Рубрикийг мэдээлэх буюу ОУБ-ын С шалгуураар үүнийг үнэлнэ. Шоколаданд дуртай байх нь хүний эрхтэй зөрчилдөх үү? Олон улсын түвшинд сэтгэдэг манай Jefferson сургуулийн 8-р ангийн сурагчдын нэгнээс асуугаад үзээрэй. Эх сурвалж: [fortune.com](http://fortune.com)



### Олон нийтийн төсөл, Үйлчлэх замаар сурах

Энэ бол бусдад туслах улирал мөн бөгөөд Jefferson сургууль үйлчлэх замаар суралцах боломжийг нэмэгдүүлж байна. Бүх БТ-ууд Арлингтоны хүнсний тусламжийн төвд зориулан лаазтай бүтээгдэхүүн цуглуулж байна. Хатагтай Voda-ийн анги 50 ширхэг сэндвич хийж, Арлингтоны гудамжны хүмүүсийн сүлжээнд хандивласан бөгөөд тэд талархан хүлээн авсан.



Олон нийтийн төслийн хувьд бид 245 гаруй зорилт, үйл ажиллагаа явуулах 30 тодорхой санал хүлээж аваад байна. Манай Шар хантаазтанууд өөрчлөлт авчирч байна. Эх сурвалж: [pixbay.com](http://pixbay.com)

### Jefferson сургууль олон нийтэд

Jefferson сургуулийн 7-р ангийнхан Арлингтоны гайхамшигтай Гадаа байдаг лабораторид ээлжлэн зочилж байна. Энэ нь АУС-ийн эзэмшлийн Фокиер нутагт байдаг 200 акр хэмжээтэй ой модтой газар юм. Манай сурагчид экологи, байгаль орчинд хүмүүсийн үзүүлэх нөлөөний талаар товч мэдээлэл авна. Дараа нь тэд залуу эрдэмтэн болохоор ой уруу орно. Тэд горхинд өрнөж буй амьдрал, үхсэн амьтан, модны амьдралын мөчлөг, амьтны мөрийг ажиглаж шинжлэхийн тулд олон өртөөгөөр ээлжлэн аялна. Үүний дараа сурагчид ил гал дээр хотдоог шарж, дараа нь Сморс идэх юм. Энэ бол бодит амьдрал дээр суралцах үйл явц байлаа. Эх сурвалж: Гэрэл зургийг ноён Malinosky авсан.



### Дэлхий даяарх үйл явц



Франц хэлний ангийнхнаас Гэгээн Николасын өдрийн (12-р сарын 6 байсан) мэнд хүргэе! Энэ өдрийг дэлхий даяар тэмдэглэдэг боловч Францад хүүхдүүд гэрийнхээ хаалганы гадаа гутлаа тавьдгаараа онцлогтой юм. Дараа нь тэд сайн байсан бол шоколад авч, мүү байсан бол мөчир авдаг. Сурагчид маань

гутал хийж, шоколад, мөчир авсан (учир нь хүн бүрд сахилгагүйтсэн нэг удаа байдаг). Эх сурвалж: Гэрэл зургийг ноён Malinosky авсан.

### Удахгүй болох арга хэмжээ, үйлчилгээний хуваарь

- Лхагва гараг бүр номын санд олон нийтийн төсөлд туслах
- Мягмар гараг бүр 17:00 цагт дугуй засахад сайнд дураар туслах Phoenix Bikes дэлгүүр дээр, 909 S. Dinwiddie St ([дэлгэрэнгүй мэдээллийг эндээс аваарай](#))
- Лхагва гараг бүр 18:30 цагт тахианы мах уутлахад сайн дураар туслах AFAC-т, 2708 S. Nelson St, ([дэлгэрэнгүй мэдээллийг эндээс аваарай](#))
- Хоолны автобусны асуудлыг зохицуулах бол [Ноён Malinosky](#) холбогдоорой
- [Сайн дурын ажлын хуваарь энд бий](#)